



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№218 /427/

2022.12.05

Цаг үе, үйл явдал

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-17	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.438	3.442
EUR	3.610	3.635
CNY	484	487
RUB	53.80	54
JPY	25.25	25.50
KRW	2.66	2.71

ЗУРХАЙ



2022.12.05 / ДАВАА ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 13

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ
ХАР ЛУУ ӨДӨР**

Үс засуулбал:
ЖАРГАЛ ИРНЭ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.25-17.00
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
САНСАР



ТОМАС ХИССЭН: МОНГОЛ ЦЭРГҮҮД ДЭЛХИЙД ЭНХТАЙВНЫГ ТОГТООЖ БАЙНА



НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн баг, тус ажиллагаанд үүрэг гүйцэтгэх 12 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний ээлж солилцох ажлыг зохион байгуулах Хөдөлгөөний хяналтын ажилтан Thomas Andrew Lango Hissen өнөөдөр Зэвсэгт хүчний Жанжин штабт айлчиллаа.

Түүнийг ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг нар хүлээн авч уулзав.

Уулзалтын үеэр НҮБ-ын төлөөлөгч, цэргийн баг солилцох үйл ажиллагааны хяналт, аюулгүй байдлын мэргэжилтэн Thomas Andrew Lango

Hissen хэлсэн үгэндээ, "Монгол Улсад буухад маш хүйтэн байлаа. Хэдий тийм ч хошууч Г.Золбадрах дулаан хувцас бэлтгэн ирж найрсгаар угтан авсанд талархаж байна. Хоёр ээлжийн бүрэлдэхүүнийг солилцох үйл ажиллагаа мэргэжлийн өндөр түвшинд маш сайн зохион байгуулалттай боллоо. Дараагийн гурван нислэг мөн өндөр түвшинд зохион байгуулагдана гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын цэргүүд БНӨСҮ-д үүргээ гайхалтай сайн биелүүлж, дэлхийд энхтайвныг тогтоож байна. Тиймээс хамгийн шилдэг шалгарсан офицеруудаа илгээж буй Монгол Улсын Зэвсэгт хүчинд талархаж байна" хэмээсэн юм.

Х.УНДАРМАА

КИБЕРИЙНХЭН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТАЙЛАГНАЖ, ОЛОЛТ АМЖИЛТАА ДҮГНЭЛЭЭ



Хууль ёс, төрөө дээдлэн хүндлэгч, шударга үнэнийг эрхэмлэгч, кибер орон зайн аливаа халдлага довтолгооноос хамгаалан тэмцэгч, аюулгүй байдлыг сахиулагчид болох ЗХЖШ-ын Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн 2022 оны үйл ажиллагаагаа нэгтгэн дүгнэж, тайлангийн хурлаа хийлээ.

Тус хуралд ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, Хяналт-шинжилгээ үнэлгээний газрын мэргэжилтэн хурандаа Х.Алтанцоож болон КАБЦК-

ын бие бүрэлдэхүүн оролцов.

КАБЦК-ын хамт олон энэ онд чамлахааргүй ажлыг амжуулсан бөгөөд цаашид Монгол Улсын аюулгүй байдлын урт болон дунд хугацааны зорилгод тулгуурласан төсөл, хөтөлбөрүүдээ үе шаттайгаар хэрэгжүүлэн, чадварлаг хүний нөөц, шилдэг техник технологи, баталгаатай орчныг бий болгох зорилт тавин ажиллаж буйгаа тайлангийн хурлын үеэр тодотголоо.

Хурлын төгсгөлд КАБЦК-ийн командлагч

бригадын генерал Д.Баасандамба албанд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжийг танилцуулсан юм.

Мөн тэрээр хуралд оролцсон удирдлагуудад тус командлалын бие бүрэлдэхүүний хамтын бүтээл болох "Кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" эмхэтгэл номын дээжийг гардуулав.

Х.УНДАРМАА

АЙМГИЙН ЦЭРГИЙН ШТАБТАЙ ХАМТРАН СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Өнгөрөгч 11 дүгээр сарын 29-ний өдөр Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас зохион байгуулсан 24 сумын Тамгын газрын дарга нар болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтад Зэвсэгт хүчний 325 дугаар ангиас дэд хурандаа Б.Батмөнх, хошууч Ц.Гантөгс, ахлах дэслэгч Г.Батболд нар оролцсон юм. Тэд "Зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, хөгжлийн чиг хандлага", "Орчин үеийн дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар" сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн юм.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 650,017,974

Эдгэрсэн

Нийт: 627,041,358

Нас барсан

Нийт: 6,646,504

Цаг үе, үйл явдал

ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛНА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат Улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллага ХХЕГ-ын Ар тал, инженер техник, зэвсэглэлийн газрын дарга хурандаа О.Баттулга, Нисэх албаны дарга бэлтгэл дэд хурандаа А.Ганболд, ОБЕГ-ын Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн захирагчийн орлогч штабын дарга дэд хурандаа Д.Батсайхан, нислэгийн аюулгүй байдал, чанар баталгаажуулалтын албаны дарга бэлтгэл хурандаа Ч.Тогоондорж нарыг энэ сарын 02-ны өдөр Агаарын цэргийн командлалд хүлээн авч уулзлаа.

Тус уулзалтаар Агаарын цэргийн өнөөгийн байдал, Улсын нисэхэд мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчин, нислэгийн аюулгүй байдал, удирдлагын баримт бичгийг боловсронгуй болгох, нисгэгч, инженер техникчдийн нийгмийн асуудлыг сайжруулах, Улсын нисэхийн агаарын хөлгүүд дээр

хамтарсан сургалт явуулах чиглэлээр санал солилцсон юм.

Уулзалтын үр дүнд ЗХЖШ-ын даргын тушаалаар ХХЕГ, ОБЕГ-ын төлөөлөгч нарыг оролцуулсан хамтарсан ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэлээ. Тус ажлын хэсэг нь Улсын нисэхэд мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчин, нислэгийн аюулгүй байдал, удирдлагын баримт бичгийг боловсронгуй болгох, Улсын нисэхийн агаарын хөлгүүд дээр хамтарсан сургалт явуулах, нисгэгч, инженер техникчдийн нийгмийн асуудлыг сайжруулах, чиглэлээр хамтран ажиллана.

Уулзалтын төгсгөлд Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат Монгол Улсад нисэхийн үйл ажиллагаа явуулж байгаа ХХЕГ, ОБЕГ-ын харьяа ангийн захирагч нарт үүрэг чиглэл өглөө.

АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

Цахим шууданд

ХИЛЧИН ДАЙЧДАД АЛБА, САЛБАРАА СУРТАЛЧИЛЛАА



Мөн хугацаат цэргийн алба хаагчид өөрсдийн бэлтгэсэн жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтыг толилуулж, урлагийн үзлэгээр мөрдэс, үйлс нэгт хилчин нөхдөдөө бэлэг барив.

Арга хэмжээний төгсгөлд тус хоёр ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд волейболын тэмцээнийг зохион байгуулж, дайчид халуун дулаан уур амьсгалтайгаар нэгэн өдрийг мартагдашгүй өнгөрүүлж, эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй хаахыг бие биедээ захиж байсан юм.

Дайчдад хандаж Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагчийн орлогч, Захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Г.Ангараг "Зорилго нэгт хилчин дайчдадаа баяр хүргэе.

Эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ ухамсарласан ийм сайхан залуусыг ангийн байрлалдаа хүлээн авч, нэгэн өдрийг хамт өнгөрүүлсэндээ манай дайчид баяртай байна" хэмээн амжилт хүссэн бол Хилийн цэргийн 0132 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Г.Чинзориг "Нэг оны цэргүүд нэг зорилгод нэгдэж, нэгнээсээ суралцаж, нөхдөөрөө бахархсан сайхан арга хэмжээ болж чадлаа" хэмээн онцлоод талархал илэрхийллээ.

Хошууч Д.Ганбаатар

ГАРДАН ТУЛААНЫ КЛУБТЭЙ БОЛЛОО



Маршал Хорлоогийн Чойбалсангийн нэрэмжит, Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дунд бие хамгаалах урлагийг сурталчлах, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах гардан тулааны тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах зорилгоор "Бригад" гардан тулааны клубийг шинээр байгуулж нээлтээ хийлээ.

Клубийн нээлтийн үйл ажиллагаанд зориулж 2022-2023 оны сургуулийн жилд зохион байгуулагдах нэгтгэлийн аварга шалгаруулах тэмцээн уралдааныг "Гардан тулаан"-ны тэмцээнээр эхлүүлж 60-65кг, 65-70кг, 70-75кг, +85кг гэсэн 4 жинд аваргуудаа тодрууллаа.

Тухайлбал 60-65кг жинд байлдагч Э.Билэгжаргал, ахлах ахлагч М.Жаргалсайхан, 65-70кг жинд байлдагч Н.Бат-Эрдэнэ, энгийн Б.Батбилгүүн, 70-75кг жинд ахлах ахлагч Ц.Содгэрэл, ахлах ахлагч Ч.Улаанхүү, +85кг жинд ахлах ахлагч н.Ганхуяг, байлдагч З.Сүххуяг нар алт, мөнгөн медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр дэд хурандаа Э.Сэрээтэр ахлагчтай артиллерийн холимог дивизийн хамт олон тэргүүлж шилжин явах цомын эзэд боллоо.



Хошууч Д.ДОЛГОРЖАВ

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №30

ГА ГИЙГҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ
ГА бол дэвсгэр үсэг, түүний дотор хатуу дэвсгэрийн нэг юм. Өмнө үзсэн ХА-г бодвол үгийн дунд, адагт ардаа эгшиггүй тохиолдож болно. Бүтэц зурлагын хувьд ХА-тай үндсэндээ адил нуман зурлагат үсэг бөгөөд ГА үсгийг өмнө нь хоёр дусал бичиж ХА-гаас ялгадаг.

Дармал, бичмэл тигээр:



ЭХ ТҮҮХЭЭРЭЭ АЯЛСАН НЭГЭН ӨДРИЙГ ӨНГӨРҮҮЛЭВ



БНМАУ-ын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Цэргийн гавьяаны одонт, Зэвсэгт хүчний 167 ангид 2022 оны II ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчид Өмнөговь аймгийн "Байгаль, түүхийн музей"-гээр зочлон говь нутгаас олдсон эртний олдворууд болон эх түүхээрээ бахархсан нэгэн өдрийг өнгөрүүллээ.

Тус музей нь дэлхийн стандартад нийцсэн засал

чимэглэл, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх бөгөөд 4000 гаруй үзмэр, эд өлгийн цуглуулгыг үзэсгэлэндээ дэлгэжээ. Тодруулбал, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрээс олдсон 4500-5000 жилийн өмнө хүн амьдарч байсан үл мөр бүхий палеонтологийн олдворуудыг дэлгэсэн байв. Мөн уран дархнуудын урлаж бүтээсэн мөнгөн аяга, гоёл чимэглэл, сав суулга, шашны эдлэл, хэрэглэл, зураг, хөгжмийн зэмсгүүд гэхчлэн түүхэн бүтээлүүдийг байрлуулсан байсан юм.